



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/187-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК
Захирал: Х.Ариунзул
Утас: 99077062 Цахим хаяг: ikhnayadaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.БОЛОРМАА ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/87/НА-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 5 дугаар түвшинд үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд

018020235

суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 85.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,603,925.11	118,062,893.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	33,876,433.89	77,104,595.58
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	33,876,433.89	77,104,595.58
3121	Төгрөг	33,876,433.89	77,104,595.58
31211	Төрийн сангийн харилцах	33,876,433.89	77,104,595.58
33	АВЛАГА	54,423.72	54,423.72
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	54,423.72	54,423.72
35	БАРАА МАТЕРИАЛ	39,673,067.50	40,903,874.22
354	Хангамжийн материал	39,673,067.50	40,903,874.22
35410	Бичиг хэргийн материал	155,000.00	155,000.00
35420	Аж ахуйн материал	25,877,691.50	24,996,914.22
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	1,654,066.00	1,954,150.00
35470	Бусад хангамжийн материал	11,986,310.00	13,797,810.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	312,320,123.84	289,593,245.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	312,320,123.84	289,593,245.44
392	Биет хөрөнгө	301,816,123.84	279,089,245.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	273,357,400.00	273,357,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(28,774,463.04)	(35,968,078.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,740,200.00	51,740,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,608,875.22)	(41,650,476.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,492,026.28	18,094,276.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,087,554.85)	(9,264,148.07)
39209	Зам, гүүрийн байгууламж	6,477,900.00	6,477,900.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,086,893.00	38,086,893.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,202,653.33)	(22,119,971.13)
39217	Ном	335,251.00	335,251.00
393	Биет бус хөрөнгө	10,504,000.00	10,504,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,504,000.00	10,504,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	385,924,048.95	407,656,138.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,075,720.80	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,075,720.80	-
413	Өглөг	1,075,720.80	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,075,720.80	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	384,848,328.15	407,656,138.96
51	Засгийн газрын хувь оролцоо	384,848,328.15	407,656,138.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	72,194,770.87	72,194,770.87
512	Хуримтлагдсан үр дүн	36,335,933.71	59,143,744.52
51210	Өмнөх үеийн үр дүн	36,335,933.71	36,335,933.71
51220	Тайлант үеийн үр дүн	-	22,807,810.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	276,317,623.57	276,317,623.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	385,924,048.95	407,656,138.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	379,616,732.00	478,587,491.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	379,616,732.00	478,587,491.59
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	325,975,500.00	435,365,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	325,975,500.00	435,365,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,642,232.00	43,221,691.59
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,642,232.00	43,221,691.59
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	367,645,778.24	457,775,103.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	367,645,778.24	457,775,103.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	367,645,778.24	457,775,103.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,431,474.07	309,560,134.42
210101	Үндсэн цалин	188,674,988.07	255,320,712.66
210102	Нэмэгдэл	47,304,875.00	46,090,105.46
210104	Урамшуулал	10,451,611.00	8,149,316.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,021,751.00	39,599,015.09
210201	Тэтгэврийн даатгал	21,908,581.82	27,386,782.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,452,180.07	3,224,114.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,897,903.98	2,504,092.18
210204	Ажилгүйдлийн даатгал	463,246.76	652,971.09
210205	Эрүүл мэндийн даатгал	4,299,838.47	5,831,054.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,072,608.74	39,751,691.59
210301	Гэрэл, цахилгаан	4,246,752.39	5,379,545.23
210302	Түлш, халаалт	20,322,424.35	32,096,046.36
210303	Цэвэр, бохир ус	3,503,432.00	2,276,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,823,770.00	1,973,600.00
210401	Бичиг хэрэг	2,394,820.00	1,973,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	113,950.00	-
210408	Бараа материал акталсны зардал	315,000.00	-
2105	Нормативт зардал	26,351,215.00	33,125,284.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,550.00	27,110.00
210502	Хоол, хүнс	26,318,665.00	33,098,174.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,685,199.88	3,470,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,049,999.88	-
210604	Урсгал засвар	4,635,200.00	3,470,000.00
2107	Томилолт, зочны зардал	192,000.00	-
210702	Дотоод албан томилолт	192,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	262,500.00	360,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	262,500.00	360,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,805,259.45	29,935,378.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,298,880.00	7,208,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	652,800.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,853,579.45	22,726,878.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	11,970,953.76	20,693,230.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	470,208.11	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	470,208.11	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (4)=(145)-(225)	(470,208.11)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	11,500,745.65	20,812,388.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	379,616,732.00	479,587,491.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	379,616,732.00	478,587,491.59
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	325,975,500.00	435,365,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	325,975,500.00	435,365,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,641,232.00	43,221,691.59
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,641,232.00	43,221,691.59
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	345,740,298.11	436,359,329.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	345,740,298.11	436,359,329.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	345,740,298.11	436,359,329.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,952,010.87	310,879,490.22
210101	Үндсэн цалин	189,694,703.87	234,463,874.38
210102	Нэмэгдэл	44,805,696.00	66,566,430.25
210104	Урамшуулал	10,451,611.00	9,849,185.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,420,493.50	39,355,380.09
210201	Тэтгэврийн даатгал	21,908,581.82	27,264,308.17
210202	Тэтгэмжийн даатгал	2,465,951.69	3,207,814.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,897,903.98	2,487,291.98
210204	Ажилгүйдлийн даатгал	507,081.11	570,250.62
210205	Эрүүл мэндийн даатгал	4,640,974.90	5,825,714.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,072,608.74	39,751,691.59
210301	Гэрэл, цахилгаан	4,246,752.39	5,379,545.23
210302	Түлш, халаалт	20,322,424.35	32,096,046.36
210303	Цэвэр, бохир ус	3,503,432.00	2,276,100.00
210401	Бичиг хэрэг		-
2105	Нормативт зардал	27,261,785.00	33,398,258.00

210502	Хоол, хүнс	27,261,785.00	33,398,258.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,635,200.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	4,635,200.00	3,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	427,500.00	360,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	427,500.00	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,970,700.00	9,144,510.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,720,700.00	7,535,910.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	1,608,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	33,876,433.89	43,228,161.69
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	33,876,433.89	43,228,161.69
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	33,876,433.89
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,876,433.89	77,104,595.58

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	72,194,770.87	276,317,623.57	24,364,979.95	372,877,374.39
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,194,770.87	276,317,623.57	24,364,979.95	372,877,374.39
Тайлант үеийн үр дүн	-	-	11,970,953.76	11,970,953.76
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	72,194,770.87	276,317,623.57	36,335,933.71	384,848,328.15
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	72,194,770.87	276,317,623.57	36,335,933.71	384,848,328.15
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,194,770.87	276,317,623.57	36,335,933.71	384,848,328.15
Тайлант үеийн үр дүн	-	-	22,807,810.81	22,807,810.81
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	72,194,770.87	276,317,623.57	59,143,744.52	407,656,138.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	512,423,591.59	436,359,329.90	76,064,261.69	85.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	512,423,591.59	436,359,329.90	76,064,261.69	85.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	512,423,591.59	436,359,329.90	76,064,261.69	85.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	374,086,200.00	310,879,490.22	63,206,709.78	83.1
210101	Үндсэн цалин	245,352,900.00	231,810,264.81	13,542,635.19	94.5
210102	Нэмэгдэл	118,550,700.00	69,220,039.82	49,330,660.18	58.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт				
210104	Урамшуулал	10,182,600.00	9,849,185.59	333,414.41	96.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,331,600.00	39,355,380.09	10,976,219.91	78.2
210201	Тэтгэврийн даатгал	34,225,500.00	27,264,308.17	6,961,191.83	79.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,026,300.00	3,207,814.90	818,485.10	79.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,221,600.00	2,487,291.98	734,308.02	77.2
210204	Ажилгүйдлийн даатгал	804,800.00	570,250.62	234,549.38	70.9
210205	Эрүүл мэндийн даатгал	8,053,400.00	5,825,714.42	2,227,685.58	72.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,751,691.59	39,751,691.59		100.0
210301	Гэрэл, цахилгаан	5,379,545.23	5,379,545.23		100.0
210302	Түлш, халаалт	32,096,046.36	32,096,046.36		100.0
210303	Цэвэр, бохир ус	2,276,100.00	2,276,100.00		100.0
2105	Нормативт зардал	35,024,900.00	33,398,258.00	1,626,642.00	95.4
210502	Хоол, хүнс	35,024,900.00	33,398,258.00	1,626,642.00	95.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,470,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	536,200.00	360,000.00	176,200.00	67.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	536,200.00	360,000.00	176,200.00	67.1
210807	Газрын төлбөр				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,223,000.00	9,144,510.00	78,490.00	99.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,614,400.00	7,535,910.00	78,490.00	99.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,608,600.00	1,608,600.00		100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	512,423,591.59	479,587,491.59	32,836,100.00	93.5

	Улсын төсвөөс санхүүжих	435,365,800.00	435,365,800.00	-	88.6
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,221,691.59	43,221,691.59	-	-
132001	Орон нутгийн төсвөөс	-	1,000,000.00	-	100.0
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,836,100.00	33,876,433.89	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		77,104,595.58	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь “*Чанартай боловсрол, таатай орчин бүрдүүлэх эерэг хандлагатай, чадварлаг баг хамт олон байхыг эрхэмлэнэ*” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ажлын байрандаа хөгжих орчин нөхцөлийг сайжруулснаар багш нарын мэдлэг боловсрол, ур чадвар, заах арга зүйг дээшлүүлж, хамт олны дунд багш нарын эерэг харилцаа хандлага, манлайллын чадварыг дээшлүүлэх
- Хүүхэд нэг бүрийн сурч хөгжих, төлөвших эрүүл орчин нөхцөлийг стандартын дагуу бүрдүүлэхэд багш ажилчид эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх
- Цахим флатформыг хэрэгжүүлэн ажиллаж мэдээллийн сантай болоход анхааран ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*

- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:*
- *"Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Шаамар 1 дүгээр цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 407,656.1 мянган төгрөг болж өмнөх оноос 21,732.7 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	33,876.4	77,104.6	43,228.2
Авлага	54.4	54.4	-
Бараа материал	39,673.1	40,903.9	1,230.8
Үндсэн хөрөнгө	312,320.1	289,593.2	(22,726.9)
Нийт хөрөнгө	385,924.0	407,656.1	21,732.1
Өр төлбөр	1,075.7	-	(1,075.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	384,848.3	407,656.1	22,807.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	385,924.0	407,656.1	21,732.1

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн данс 77,104.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 40,903.9 мянган төгрөг болж 1,230.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 42,945.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 41,715.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 289,593.2 мянган төгрөг болж 22,726.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 278,200.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 43,221.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 321,422.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 191,001.6 мянган төгрөгийн орлогыг нэмэгдүүлэн тооцож улсын төсвөөс 435,365.8 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 43,221.7 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс 33,836.1 мянган төгрөгийг төвлөрүүлэн нийт 512,423.6 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 435,365.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 43,221.7 мянган төгрөг, урьд оны санхүүжилтээс 33,836.1 мянган төгрөг нийт 512,423.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 436,359.3 мянган төгрөг буюу 85.2 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 63,206.7 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 10,976.2 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 1,626.6, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 176.2 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 78.5 мянган төгрөгөөр мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	898.7	804.2	94.5	89.5
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	35,024.9	33,398.2	1,626.7	95.3
		3	81816- Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	1,630.4	1,630.4	-	100.0
		4	81823- Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	898.7	726.0	172.7	80.8
		5	81834- Боловсролын стандарт сургалт	430,749.2	356,578.8	74,170.4	82.3
		6	80111- Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	43,221.7	43,221.7	-	-
		Нийт		512,423.6	436,359.3	76,064.3	85.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хүүхдийн хоол хүнсний материал худалдан авахаар 35,024.9 мянган төгрөг төсөвлөсөн байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг tender.gov.mn цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаанд шалгарсан АМСОӨР ХХК-тай гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Их наяд аудит” ХХК-ийн аудитор Х.Ариунтуяа гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Их наяд аудит” ХХК -д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 365,240.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,652.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээлэл байршуулахаас тус байгууллага нь мэдээллийг цаг хугацаанд нь ил тод, бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2023 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 7,191.3 мянган төгрөгийн 3 алдаа

илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,086.5 мянган төгрөгийн цахим төлбөрийн баримтгүй гүйлгээ хийсэн, өр төлбөр үүсгэсэн асуудалд 2 албан шаардлага, санхүүгийн иж бүрэн байдлын талаарх зөрчилд 1 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлэн, хариуг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	2	3,086.5	2	3,086.5	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	3	3,086.5	3	3,086.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

2. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,191.3 мянган төгрөгийн алдаа 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ 5,632.6 мянган төгрөгийн цахим төлбөрийн баримт дутуу бүрдүүлсэн.
2. Цалингийн зардлыг журналд тусгахдаа 1,558.7 мянган төгрөгийг илүү бүртгэж тайлагнасан.

Аудитаар нийт 54.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1. Зөвлөмж

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайлан дахь 54.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй, авлага барагдуулах арга хэмжээ аваагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Авлага барагдуулах ажлыг зохион байгуулж, үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулах.

2. Зардлын данстай холбоотой

2.1 Илрүүлэлт: Шаамар сумын Засаг даргын тамгын газарт үндсэн орон тоонд нягтлан бодогчоор ажиллаж буй А.Сэргэлэнг Шаамар сумын 1, 2 дугаар цэцэрлэгт зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр нягтлан бодогчоор ажиллуулан, цалинжуулж / цэцэрлэг тус бүрээс үндсэн цалингийн 80.0 хувиар тооцож / байгаа нь дараах хуулиудыг тус тус зөрчиж байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх “Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ” 37.1.17: “Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх”,
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх “Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ”, 38.1.6: “Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх”, 38.1.7: “Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх...”,
- Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина”, 84 дүгээр зүйлийн 84.4 дэх “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” зэрэг.

2.2 Өгсөн зөвлөмж: 3 байгууллагад зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоож, зайлшгүй тохиолдолд цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Цахим баримтгүй худалдан авалт гүйцэтгэсэн	1	5,632.6			1	5,632.6							
Цалингийн зардлыг журналд илүү тайлагнасан	1	1,558.7			1	1,558.7							
Дүн	2	7,191.3			2	7,191.3	2	7,191.3	2	7,191.3			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй	1	54.4						1	54.4			
Нягтлан бодогчийг зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсан	1							1				
Дүн	2	54.4						2	54.4			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил						Үүнээс					
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												